# СОНГУУЛЬ БА ЖЕНДЭР
# 2024

СОНГУУЛИЙН ХҮЙСЭЭР АНГИЛСАН
**НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ДҮРСЛЭЛ**

ННА 66
ДАА 320
С-568

# СОНГУУЛЬ БА ЖЕНДЭР

## СОНГУУЛИЙН ХҮЙСЭЭР АНГИЛСАН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ДҮРСЛЭЛ 2024

Санаачлагч, хэрэгжүүлэгч

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО | ТУНГААХУЙ ӨГӨГДЛИЙН УРЛАН

Товхимол боловсруулсан

ТУНГААХУЙ ӨГӨГДЛИЙН УРЛАН

Энэхүү товхимолыг “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслөөс санхүүжүүлэв.

Товхимолд тусгагдсан агуулга, дүгнэлтүүд гүйцэтгэгч байгууллагын байр суурийг илэрхийлж байгаа бөгөөд төслийг санхүүжүүлэгч БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/ болон хэрэгжүүлэгч НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн байр суурийг илэрхийлээгүй болно.

**CC BY-ND 4.0**

Товхимолыг бүтнээр нь, зохиогчийг дурдах нөхцөлтэйгөөр чөлөөтэй ашиглах, нийтлэх, түгээх боломжтой. Өөрчлөлт оруулах, хувиргах, хэсэгчлэн ашиглах, тухайн бүтээлд үндэслэн үүсмэл бүтээл үүсгэхийг хориглоно.

Товхимолд орсон бүх байгууллагын лого нь зөвхөн таних зориулалттай бөгөөд зохиогчийн эрх болон лицензийн хамгаалалтад хамаарахгүй.

ISBN 978-9919-0-5881-4

©ТУНГААХУЙ ӨГӨГДЛИЙН УРЛАН ХХК 2025

Сонгуулийн өгөгдөл, ойлголт, эрх зүйн зөвлөхүүд:

Д.БАТ-ЭРДЭНЭ | Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга

Т.ГҮЕНБААТАР | Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн Ахлах референт

П.АЛТАНЧИМЭГ | Сонгуулийн ерөнхий хорооны Улс төрийн намын мэдээлэл, арга зүйн газрын Референт

Г.ПҮРЭВСҮРЭН | Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн Референт

Д.ЭНХЦЭЦЭГ | Нээлттэй нийгэм форумын Засаглалын хөтөлбөрийн менежер

Э.ЭРДЭНЭЧИМЭГ | “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн Менежер

Э.ГЭРЭЛТ-ОД | “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн Техникийн зөвлөх

Жендэрийн зөвлөхүүд:

Б.АНХБАЯР | Тунгаахуй өгөгдлийн урлангийн Жендэрийн зөвлөх

Э.ЭНХЧИМЭГ | “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн Жендэрийн шинжээч

# СОНГУУЛЬ БА ЖЕНДЭР

## СОНГУУЛИЙН ХҮЙСЭЭР АНГИЛСАН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ДҮРСЛЭЛ

## 2024

Сонгуулийн хүйсээр ангилсан
өгөгдлийн дүрслэлийн нээлттэй сан

www.tungaahui.mn

АГУУЛГА


4 ..... Товчилсон үг
5 ..... Удиртгал

7 ..... Сонгуулийн хүйсээр ангилсан нээлттэй өгөгдөл 1

13 ..... Сонгууль ба жендэр: Өнөөгийн дүр зураг 2

21 ..... Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн хүйсээр ангилсан нээлттэй өгөгдөл 3

59 ..... Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн хүйсээр ангилсан нээлттэй өгөгдөл 4

87 ..... Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн хүйсээр ангилсан нээлттэй өгөгдөл 5

# ТОВЧИЛСОН ҮГ

| | |
|---|---|
| БНСУ | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| НҮБ | Нэгдсэн үндэстний байгууллага |
| ОУПХ | Олон улсын парламентын холбоо |
| СЕХ | Сонгуулийн ерөнхий хороо |
| УБЕГ | Улсын бүртгэлийн ерөнхий газар |
| УИХ | Улсын Их Хурал |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |

# УДИРТГАЛ

**Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо, Тунгаахуй өгөгдлийн урлан** хамтран **НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (KOICA)-ын санхүүжилттэй "Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь" төслийн** дэмжлэгтэйгээр Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит болон 2025 оны нөхөн сонгуулийн хүйсээр ангилсан өгөгдлийг нарийвчлан бүрдүүлж, эдгээр өгөгдөлд суурилсан өгөгдлийн дүрслэл (data visualization)-ийн нээлттэй сан бүтээв.

**Сонгуулийн хүйсээр ангилсан өгөгдлийн дүрслэлийн нээлттэй сан** нь төрийн нээлттэй өгөгдлийг "өгөгдлийн дүрслэл" хэлбэрийн бүтээгдэхүүн болгон хөгжүүлж, нээлттэй сан үүсгэн олон нийтэд танилцуулж буйгаараа онцлогтой. Өгөгдлийн дүрслэлийн нээлттэй сан дахь бүтээлүүдийг бүтнээр нь, зохиогчийг дурдах нөхцөлтэйгөөр чөлөөтэй ашиглах, нийтлэх, түгээх (CC BY-ND 4.0 лиценз) боломжтой.

Энэхүү товхимол болон өгөгдлийн дүрслэлийн нээлттэй сангаас сонгогчид, нэр дэвшигчид, сонгуулийн ирц, үр дүн гэх мэт сонгуулийн бүхий л үйл явц дахь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оролцооны талаар өгөгдөлд суурилсан бодит ойлголт, мэдээлэл авах, сонгуулийн жендэрийн тэгш байдлын талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, судалгаа хийх боломж нэмэгдэнэ гэж итгэж байна.

# СОНГУУЛИЙН ХҮЙСЭЭР АНГИЛСАН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ

# 1

# **СОНГУУЛЬ** ГЭЖ ЮУ ВЭ?

Иргэд сонгох, сонгогдох эрхээ эдлэн улс төрийн шийдвэр гаргах үйл явцыг **СОНГУУЛЬ** гэнэ.

Сонгууль нь сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, төрийн тэргүүнээ сонгох, төрийн эрх барих дээд байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагыг өөрсдийн төлөөллөөр бүрдүүлэх үндсэн арга юм.

# СОНГУУЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ

> “Нээлттэй өгөгдөл гэж хэн бүхэн чөлөөтэй ашиглаж, шинэ зорилгоор дахин хэрэглэж, дахин түгээж болдог, нээлттэй байдлыг баталгаажуулсан лицензтэй өгөгдөл юм.
>
> *Open Knowledge Foundation*

Нээлттэй өгөгдөл нь өгөгдөл ямар нэг хязгаарлалтгүйгээр нээлттэй байх, түүнийг бодит хэрэглээнд оруулж, үнэ цэн бүтээх тухай ойлголт дээр суурилан хөгжиж байна. Монгол Улс нээлттэй өгөгдлийн суурь зохицуулалтыг багтаасан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг 2021 онд баталсан. Тус хуульд анх удаа нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдөл болгох тухай тусгаж, мэдээлэл хариуцагч төрийн байгууллагууд өгөгдлөө нээлттэй нийтлэх үүрэг хүлээсэн.

Сонгуулийн өгөгдөл бол төрийн нээлттэй өгөгдөлд хамаарах чухал өгөгдөл. Сонгуулийн холбоотой эрхийг хангах, сонгуулийн бүх нийтийн зарчмыг хэрэгжүүлэх, сонгуулийн хүртээмжтэй, нээлттэй, ил тод байдлыг хангах нэг хэрэгсэл бол нээлттэй өгөгдөл юм. Сонгуулийн нээлттэй өгөгдөл хөгжүүлэх нь дан ганц өгөгдлийг нээлттэй нийтлэх тухай асуудал бус, илүү үнэ цэн бүтээхийн тулд нээлттэй өгөгдлийн шаардлагуудыг хангахуйц байдлаар “нээх” шаардлага бий. Өгөгдөл бүрэн, нарийвчилсан, үүссэн даруйд нь нийтэлсэн болон нээлттэй өгөгдлийн бусад шаардлагуудыг хангасан байх тусам үнэ цэнтэй болно.

Сонгуулийн чанартай нээлттэй өгөгдөл бүрдсэнээр иргэд сонгогчид, улс төрийн намууд, нэр дэвшигчид, иргэний нийгмийн байгууллагууд, сэтгүүлчид, ажиглагчид, судлаачид гэх мэт олон талт оролцогч талууд мэдээлэл авах, сонгуулийн үйл явцыг ойлгох, хянах, хэлэлцүүлэг өрнүүлэх, сонгуулийн судалгаа хийх боломжийг олгож, илүү хүртээмжтэй, ил тод, нээлттэй сонгууль явуулахад тусална.

# НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ШААРДЛАГА

- БҮРЭН
- ҮНЭН ЗӨВ
- НАРИЙВЧИЛСАН
- ҮҮССЭН ДАРУЙД НЬ НИЙТЭЛСЭН
- ЧӨЛӨӨТЭЙ ХАНДАХ БОЛОМЖТОЙ
- ЧӨЛӨӨТЭЙ АШИГЛАХ БОЛОМЖТОЙ
- МАШИН БОЛОВСРУУЛАХ БОЛОМЖТОЙ
- ЯЛГАВАРЛАЛГҮЙ
- ӨМЧЛӨЛГҮЙ
- ТӨЛБӨРГҮЙ
- БАЙНГЫН, ТОГТВОРТОЙ
- ХАРЬЦУУЛАГДДАГ

# СОНГУУЛИЙН ХҮЙСЭЭР АНГИЛСАН ӨГӨГДӨЛ

Ардчилсан улс орнуудад сонгуулийн нэг шаардлага нь жендэрийн тэгш байдлыг хангах явдал байдаг. Төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх, сонгуулийн үйл явцад тэгш оролцооны зарчмыг хэрэгжүүлэхэд жендэрийн сэдэв зайлшгүй хөндөгдөнө. Цаашлаад хүйсийн төдийгүй бусад онцлог бүлгүүдийн оролцооны талаар өгөгдөл бүрдүүлэх нь иргэдийн сонгох, сонгогдох эрх хэр хангагдаж буйн хэмжүүр болно.

Сонгуулийн нээлттэй өгөгдлийг хүйсээр ангилан бүрдүүлэх нь нээлттэй өгөгдлийн “нарийвчилсан” байх шаардлагыг хангахаас гадна өгөгдлийг хүний эрхэд суурилсан хандлагаар буюу “хэнийг ч орхигдуулахгүй” зарчмаар[1] бүрдүүлж буй хэлбэр юм. Энэ нь хүн амын ялгаатай бүлгүүдийн нөхцөл байдлыг ойлгох, харьцуулах, тэгш бус байдалд анхаарал хандуулах боломж олгоно.

Сонгуулийн хүйсээр ангилсан өгөгдлийг бүрдүүлэхдээ сонгуулийн бүхий л үе шатанд сонгогч, нэр дэвшигч, сонгогдсон албан тушаалтан, сонгуулийн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн сонгуулийн ажилтан, ажиглагч гэх мэт оролцогч талуудын хүйсийн тэгш оролцоо хангагдаж буй эсэхийг үнэлэхүйц байдлаар нарийвчлан бүрдүүлэх шаардлагатай. Цаашид сонгуулийн өгөгдлийг хүйсээс гадна үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, боловсролын түвшин гэх мэт олон үзүүлэлтээр нарийвчлан бүрдүүлэх хэрэгцээ бий.

[1] “A Human Rights Based Approach to Data”, 2018, Office of the UN High Commissioner for Human Rights

# СОНГУУЛЬ БА ЖЕНДЭР: ӨНӨӨГИЙН ДҮР ЗУРАГ

# 2

# ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсад ардчилсан сонгууль явагдаж эхэлснээс хойш сонгуулийн хууль, эрх зүйн орчинд олон шинэчлэл хийгдсэн бөгөөд тэдгээрийн нэг нь хүйсийн төлөөллийн доод хязгаар (квот) тогтоосон явдал юм. Квот буюу аль нэг хүйсийн төлөөллийн доод хязгаарыг тогтоох нь шийдвэр гаргах түвшинд хүйсийн төлөөллийн тэнцвэрийг хангах зорилгоор дэлхийн олон улс оронд хэрэгжүүлдэг, тэгш оролцоог баталгаажуулах чухал арга гэж үздэг.

# УИХ-Д НЭР ДЭВШҮҮЛЭХ ХҮЙСИЙН ТӨЛӨӨЛЛИЙН ДООД ХЯЗГААР /КВОТ/

УИХ-д сонгогдсон эмэгтэй гишүүд

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХҮЙСИЙН КВОТ

| Он | УИХ-д сонгогдсон эмэгтэй гишүүд | Нэр дэвшүүлэх хүйсийн квот | Тайлбар |
|---|---|---|---|
| 1992 | 3 эмэгтэй гишүүн сонгогдов. | | |
| 1996 | 8 эмэгтэй гишүүн сонгогдов. | | |
| 2000 | 9 эмэгтэй гишүүн сонгогдов. | | |
| 2004 | 5 эмэгтэй гишүүн сонгогдов. | | |
| 2005 | | 30% | Анх удаа нэр дэвшигчийн хүйсийн квотыг санаачилж, сонгуулийн хуульд тусгав. |
| 2007 | | | Сонгуулийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр квотын заалт хэрэгжиж эхлэхээс өмнө цуцлагдав. |
| 2008 | 3 эмэгтэй гишүүн сонгогдов. | | |
| 2012 | 11 эмэгтэй гишүүн сонгогдов. | 20% | 2011 онд сонгуулийн хуульд нэр дэвшигчийн хүйсийн квотыг дахин тусгасан нь хэрэгжив. |
| 2015 | | 30% | Сонгуулийн хуульд нэр дэвшигчийн хүйсийн квотыг нэмэгдүүлж тусгав. |
| 2016 | 13 эмэгтэй гишүүн сонгогдов. | 20% | Нэр дэвшигчийн хүйсийн нэмэгдүүлсэн квот хэрэгжиж эхлэхээс өмнө квотыг эргүүлэн бууруулав. |
| 2020 | 13 эмэгтэй гишүүн сонгогдов. | 20% | 2019 онд сонгуулийн хуульд нэр дэвшигчийн хүйсийн квотыг хэвээр тусгасан нь хэрэгжив. |
| 2024 | 32 эмэгтэй гишүүн сонгогдов. | 30% | 2023 онд сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт орж, хүйсийн квотыг нэмэгдүүлсэн нь хэрэгжив. |
| 2028 | | 40% | 2023 онд сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт орж, хүйсийн квотыг дахин нэмэгдүүлж тусгав. |

# ӨНӨӨГИЙН ДҮР ЗУРАГ

2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн холимог тогтолцооны үр дүнд Монгол Улсын парламентын түүхэнд хамгийн олон эмэгтэй гишүүн сонгогдов. Энэ нь Монгол Улсын сонгуулийн 100 жилийн түүхэнд анх удаа бага хүйсийн төлөөлөл буюу эмэгтэйчүүдийн төлөөлөл нийт гишүүдийн 25%-иас дээш хувийг бүрдүүлсэн тохиолдол юм.

Улсын Их Хурлын 126 гишүүнээс 32 эмэгтэй гишүүн сонгогдож, парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 25.4%-д хүрсэн нь Ази тивийн дундаж (21.2%)-аас өндөр, дэлхийн дундаж (26.9%)-тай хамгийн ойртоод буй амжилт юм.

Монгол Улсад парламент нийт 30 удаа өөрчлөн бүрдсэнээс мэдээлэл бүртгэгдсэн 26 тохиолдлын 12 удаад нь сонгогдсон гишүүдийн 20%-иас дээш хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байжээ.

2024 онд эмэгтэйчүүд УИХ-д өмнөхөөсөө илүү олон сонгогдсон нь сонгуулийн хуульд оруулсан өөрчлөлттэй шууд холбоотой. Тодруулбал, жагсаалтаар сонгогдох гишүүдийн хүйсийн харьцааг 50/50 байхаар тогтоож, нэр дэвшигчдийг жагсаалтад хүйсээр ээлжилж бичих зохицуулалт нэвтрүүлснээр эмэгтэйчүүдийн төлөөлөл мэдэгдэхүйц өсөв. 2024 оны сонгуульд жагсаалтаар 24 эмэгтэй, тойргуудаас 8 эмэгтэй гишүүн сонгогдсон.

2024 оны сонгуулиар тойрогт өрсөлдөж, сонгогчдын саналаар ялалт байгуулсан эмэгтэй гишүүний тоо найм (нийт 78 суудлаас) байгаа нь 2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар 13 эмэгтэй (нийт 76 суудлаас) сонгогдсонтой харьцуулахад буурсан үзүүлэлт байв. Эмэгтэйчүүд тойргийн мандатаар сонгогдох хувь харьцангуй бага байгаа нь ямар шалтгаантай вэ? Үүнийг дараах хүчин зүйлстэй холбож болох юм:

- Сонгуулийн зардлын өндөр дарамт
- Томсгосон тойрог, сонгуулийн сурталчилгааны богино хугацаа
- Олон нийтэд танигдсан эмэгтэй нэр дэвшигчид цөөн
- Зарим эмэгтэй нэр дэвшигчдийг мерит бус зарчмаар нэр дэвшүүлсэн байдал
- Өмнөх парламентад сонгогдсон зарим эмэгтэй гишүүдийн ёс зүйн асуудал хэвлэл мэдээлэл болон нийгмийн сүлжээнд дуулиан дагуулсан нь эмэгтэй улс төрчдийн нийтлэг дүр төрхөд сөргөөр нөлөөлсөн
- Жендэрийн хэвшмэл ойлголт, эцгийн эрхт ёсны соёлын элементүүд амь бөхтэй оршиж, олон нийтийн мэдлэг, мэдээллийг сайжруулах хэрэгцээ хэвээр байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын түвшинд хүйсийн төлөөлөл ямар дүр зурагтай байна вэ? Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн нэр дэвшилтээс харахад нийт 17,278 хүн нэр дэвшсэний 32.4% нь эмэгтэй, 67.6% нь эрэгтэй нэр дэвшигчид байсан.

Сонгуулийн дүнгийн тухайд ИТХ-д сонгогдсон 8,031 төлөөлөгчийн 27.6% нь эмэгтэйчүүд байв. Үүнээс, аймаг, нийслэлийн түвшинд эмэгтэй төлөөлөгчид 18.0%-ийг, сум, дүүргийн түвшинд 28.6%-ийг бүрдүүлсэн. Эдгээр тоон үзүүлэлт нь том хэмжээний, илүү их санхүүжилт шаарддаг тойргууд эмэгтэй нэр дэвшигчдийн амжилтанд саад болж байгааг илтгэнэ.

Энэ дүр зураг нь орон нутгийн түвшинд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих бодлого, стратегийн чухлыг онцолж байна.

Түүнчлэн ирээдүйн сонгуулиудад улс төрийн оролцооны туршлагатай, олон нийтийн итгэлийг олсон эмэгтэй манлайлагчдыг төлөвшүүлэх, дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Энэ нь зөвхөн сонгуулийн механизмаар бус, олон нийтийн ойлголт, хэвшмэл ойлголтыг өөрчлөх боловсрол, мэдээллийн ажлуудтай хамт явагдах шаардлагатайг ч харуулж байна.

# ИХ ХУРАЛ ДАХЬ ЭМЭГТЭЙ ГИШҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ 1924-2024






Эх сурвалж: 1924-1949 оны мэдээлэл: Үндэсний төв архив, Архивын эх сурвалжаас, 2024.10.28;

1951-1990 оны мэдээлэл: ОУПХ, Парламент дахь эмэгтэйчүүд, 1945-2018;

1992-2020 оны мэдээлэл: Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүд, ҮСХ, 2023.

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ХҮЙСЭЭР АНГИЛСАН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ

3

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТОВЧООН

Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, УИХ-ын гишүүдийг дөрвөн жил тутам явагддаг ээлжит сонгуулиар сонгодог.

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталснаас хойш есөн удаа УИХ-ын сонгуулийг зохион явуулжээ.





2008
МАЖОРИТАР
Олон мандаттай
2012
ХОЛИМОГ
Мажоритар 48
Пропорционал 28
2016
МАЖОРИТАР
Нэг мандаттай
2020
МАЖОРИТАР
Олон мандаттай
2024
ХОЛИМОГ
Мажоритар 78
Пропорционал 48
76
1,542,617
2,564,285
76.5%
311
45
12
1
76
1,840,824
2,801,136
67.3%
518
26
11
2
76
1,911,047
3,057,778
73.6%
429
69
12
3
76
2,003,969
3,328,315
73.6%
485
121
14
3
126
2,089,949
3,504,741
69.4%
1,299
42
19
2
Мандатын тоо
Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо
Хүн амын тоо
Сонгуулийн ирц
Нам, эвслээс нэр дэвшигчдийн тоо
Бие даан нэр дэвшигчдийн тоо
Сонгуульд оролцсон намын тоо
Сонгуульд оролцсон эвслийн тоо

# СОНГОГЧ

Сонгогч гэж сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг хэлнэ. Сонгогчдын нэрийн жагсаалт нь сонгуульд оролцох эрх бүхий нийт иргэдийн бүртгэл бөгөөд иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэдэг.

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтад 2024 оны 06-р сарын 05-ны байдлаар нийт 2,238,005 сонгуулийн насны хүн бүртгэлтэй байсан бөгөөд 52.2% нь эмэгтэй, 47.8% нь эрэгтэй хүн байв. Монгол Улсын нийт хүн амын дунд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хүйсийн харьцаа харгалзан 49.0% ба 51.0% байгаатай[2] харьцуулахад сонгуулийн насны хүн амын дунд эмэгтэйчүүдийн хувь илүү байна.

Сонгуулийн насны хүний насны төлөөллийн хувьд харьцангуй залуу буюу 50.3% нь 18-39 насны иргэд, 20.5% нь 40-49 насны иргэд, үлдсэн 29.2% нь 50 болон түүнээс дээш насны иргэд ажээ. Хүн амын насны бүлэг дэх хүйсийн ялгаа нас ахих тусам эмэгтэйчүүд давамгайлах байдлаар нэмэгддэг хандлага сонгуулийн насны хүний хувьд мөн илэрч, 49 хүртэлх насанд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хүйсийн харьцаа тэнцүү бол 50 ба түүнээс дээш насанд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хүйсийн харьцаа харгалзан 43.3% ба 56.7% байна.

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд гадаад улсад байгаа 13,095 иргэн оролцохоор бүртгүүлсэн бөгөөд эдгээр сонгогчдын 59.2% нь эмэгтэй, 40.8% нь эрэгтэй сонгогчид байв.

[2] Хүн амын тоо, 2023, ҮСХ


Сонгуулийн насны нийт хүний тоо: 2,238,005
/2024.06.05-ны байдлаар, УБЕГ/
Сонгуулийн насны хүний тоо
2,238,005
Мандатын тоо
78
Эрэгтэй
48%
Эмэгтэй
52%
50%
50%
Нэг мандатад ногдох сонгуулийн насны хүний тоо
28,692
1-р тойрог
Архангай, Өвөрхангай, Баянхонгор
192,081
49%
51%
2-р тойрог
Говь-Алтай, Завхан, Ховд, Увс
196,246
50%
50%
3-р тойрог
Баян-Өлгий
69,075
49%
51%
4-р тойрог
Булган, Хөвсгөл, Орхон
201,041
49%
51%
5-р тойрог
Дархан-Уул, Сэлэнгэ, Төв
204,178
50%
50%
6-р тойрог
Дорнод, Сүхбаатар, Хэнтий
146,548
50%
50%
7-р тойрог
Дорноговь, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь
135,738
50%
50%
8-р тойрог
Баянзүрх
275,226
46%
54%
9-р тойрог
Баянгол
166,287
44%
56%
10-р тойрог
Сүхбаатар, Чингэлтэй
206,134
47%
53%
11-р тойрог
Сонгинохайрхан
220,690
48%
52%
12-р тойрог
Хан-Уул
175,377
44%
56%
13-р тойрог
Багануур, Багахангай, Налайх
49,384
49%
51%
21,342
19,625
23,025
25,130
20,418
20,935
19,391
55,045
55,429
34,356
44,138
58,459
24,692

Сонгогчдын  нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгуулийн насны хүний тоо, насны бүлгээр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ



| | Нийт | Эрэгтэй (%) | Эмэгтэй (%) |
|---|---|---|---|
| БНСУ | 2,983 | 38% | 62% |
| АНУ | 1,862 | 44% | 56% |
| Япон | 1,441 | 44% | 56% |
| Австрали | 1,282 | 49% | 51% |
| БНХАУ | 823 | 33% | 67% |
| ХБНГУ | 631 | 32% | 68% |
| ОХУ | 545 | 41% | 59% |
| Унгар | 466 | 41% | 59% |
| Чехийн БНУ | 443 | 48% | 52% |
| Их Британи | 415 | 34% | 66% |
| Швед | 271 | 42% | 58% |
| Швейцарь | 267 | 30% | 70% |
| Австри | 202 | 39% | 61% |
| Казахстан | 189 | 54% | 46% |
| Бельги | 187 | 36% | 64% |
| Польш | 181 | 39% | 61% |
| Франц | 167 | 34% | 66% |
| Турк | 150 | 39% | 61% |
| Канад | 114 | 39% | 61% |
| Сингапур | 65 | 43% | 57% |
| Итали | 60 | 20% | 80% |
| Тайланд | 46 | 37% | 63% |
| Хонконг | 40 | 43% | 58% |
| Энэтхэг | 35 | 40% | 60% |
| Болгар | 33 | 42% | 58% |
| Вьетнам | 31 | 42% | 58% |
| Лаос | 30 | 53% | 47% |
| Киргиз | 30 | 47% | 53% |
| Узбекистан | 24 | 38% | 63% |
| Арабын Нэгдсэн Эмират | 22 | 32% | 68% |
| Беларусь | 21 | 57% | 43% |
| Куба | 15 | 33% | 67% |
| Египет | 12 | 42% | 58% |
| Кувейт | 12 | 42% | 58% |

## ГАДААД ДАХЬ СОНГОГЧИД

13,095




**34 Улс**

**47 Хот**

# НЭР ДЭВШИГЧ

Монгол Улсын Их Хурлын өмнөх найман удаагийн сонгуулийн нэр дэвшигчдийн статистикаас харахад эмэгтэй хүйсийн төлөөлөл үргэлж бага буюу 1.4%-32.0% байжээ. Харин 2024 оны сонгуулиар нэр дэвшсэн нийт 1341 нэр дэвшигчийн 520 нь эмэгтэй буюу бага хүйсийн төлөөллийн хувь 38.8% болов. Энэ үзүүлэлт нь Монгол Улсын Парламентын сонгуулийн түүхэнд хамгийн өндөр үзүүлэлт болсон юм.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд 19 нам, хоёр эвслээс 1299, бие даан нэр дэвшигч 42, нийт 1341 нэр дэвшигч өрсөлдсөн.

Нам, эвслээс нэр дэвшигчдийн 60.0% нь эрэгтэй, 40.0% нь эмэгтэй нэр дэвшигчид, харин бие даан нэр дэвшигчдийн нэг нь буюу 2.4% нь эмэгтэй нэр дэвшигч байв. Хуульд заасан хүйсийн төлөөллийн квотын дагуу бүх нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ нэг хүйсийн төлөөллийг 30%-иас доошгүй байх шаардлагыг хангасан нь эмэгтэй нэр дэвшигчдийн хувийг өмнөх сонгуультай харьцуулахад даруй 14%-иар нэмэгдүүлж чадсан. Харин квот заагаагүй бие даан нэр дэвшигчдийн хувьд эмэгтэй хүйсийн төлөөлөл маш бага хэвээр байна.




Нийт нэр дэвшигчид
Эмэгтэй нэр дэвшигчид
1992
293
4
(1.4%)
1996
302
8
(2.6%)
2000
602
9
(1.5%)
2004
244
33
(13.5%)
2008
356
66
(18.5%)
2012
544
174
(32.0%)
2016
498
129
(25.9%)
2020
606
151
(24.9%)
2024
1,341
520
(38.8%)

## Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвслээс нэр дэвшүүлэхдээ хүйсийн квотыг хэрхэн хангасан бэ?

Нам, эвслээс 2024 онд нэр дэвшүүлсэн эмэгтэй хүйсийн төлөөллийн хувь хамгийн багадаа 30%, хамгийн ихдээ 60% (нэг нэр дэвшигчтэй хоёр намыг эс тооцвол) байв.

Сонгуульд өрсөлдөж буй 19 намаас эмэгтэй нэр дэвшигчийн төлөөлөл 50%-иас дээш хоёр нам, 40%-50% бүхий найман нам, 30%-40% бүхий долоон нам байгаа бөгөөд хоёр нам тус бүр нэг нэр дэвшигчтэй бөгөөд тэд эрэгтэй нэр дэвшигчид байна. Харин хоёр эвслийн хувьд 33%-40% -ийн эмэгтэй төлөөллийг нэр дэвшүүлжээ.

Намууд сонгуулийн хуульд заасан 30%-ийн хүйсийн квотыг хангасан. Гэхдээ нэр дэвшигчдийн тоо цөөн намуудын хувьд хүйсийн харьцаа илүү тэнцвэртэй, эсвэл эмэгтэй хүйсийн төлөөлөл илүү байх хандлага ажиглагдаж байна. Мөн шинэ залуу намууд хүйсийн харьцааг харьцангүй тэнцвэртэй хангаж, манлайлал үзүүлж байна.

Эмэгтэй нэр дэвшигчдийн төлөөлөл 50%-иас давсан хоёр нам байна. Тэдгээр нь Иргэдийн оролцооны нэгдэл нам болон Ард түмний хүч нам бөгөөд тус бүр 57–60 нэр дэвшигчтэй сонгуульд оролцсон. Эдгээр намууд харгалзан 2015, 2020 онд байгуулагдсан харьцангуй залуу намууд юм.

Нөгөө талд нэр дэвшигчдийн тоогоор тэргүүлэгч Монгол ардын нам, Ардчилсан нам намууд (тус бүр 126 нэр дэвшигч дэвшүүлсэн) хуульд заасан 30%-ийн квотыг тулган хангажээ. Харин нэр дэвшигчдийн тоогоор эдгээр намын дараа орох хэдий ч Иргэний хөдөлгөөний намын эмэгтэй төлөөлөл 43.5%, ХҮН намын эмэгтэй төлөөлөл 46.7% байгаа нь залуу намуудын (2007 ба 2011 онд байгуулагдсан) онцлог байж болох. Эмэгтэй нэр дэвшигчдийн төлөөлөл 40–50%-д хүрсэн найман нам бүгд 2000–2023 оны хооронд байгуулагдсан нь шинэ үеийн намууд хүйсийн харьцааг илүү тэнцвэртэй хангах чиг хандлагатай байгааг харуулж байна.


Монгол ардын нам
126
78
48
70%
30%
Ардчилсан нам
126
78
48
70%
30%
Иргэний хөдөлгөөний нам
124
76
48
56%
44%
ХҮН нам
122
75
47
53%
47%
Шинэ нэгдсэн эвсэл
90
53
37
67%
33%
Үнэн ба зөв нам
80
62
18
64%
36%
Иргэний зориг ногоон нам
72
60
12
58%
42%
Ард түмний олонхийн засаглал нам
71
44
27
65%
35%
Үндэсний эвсэл
70
45
25
60%
40%
Ард түмний хүч нам
60
52
8
48%
52%
Иргэдийн оролцооны нэгдэл нам
57
53
4
40%
60%
Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам
55
37
18
53%
47%
Бүгд найрамдах нам
54
39
15
61%
39%
Эрх чөлөөний эвсэл нам
47
43
4
53%
47%
Эх орон нам
43
39
4
70%
30%
Монголын хүний төлөө нам
42
38
4
60%
40%
Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам
30
25
5
57%
43%
Монгол консерватив нам
22
22
0
59%
41%
Монголын социал демократ нам
6
6
0
67%
33%
Монголын либерал ардчилсан нам
1
1
0
100%
Эх орончдын нэгдсэн нам
1
1
0
100%
Бие даан нэр дэвшигч
42
42
0
98%
2%
Нийт нэр дэвшигч
1,341
Тойрогт нэр дэвшигч
969
Жагсаалтаар нэр дэвшигч
372
Эрэгтэй (нийт нэр дэвшигчдэд эзлэх хувь) 61%
Эмэгтэй (нийт нэр дэвшигчдэд эзлэх хувь) 39%

## ЭМЭГТЭЙ НЭР ДЭВШИГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ТОЙРГООР

42.3% Тойрог 7 (Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь)
42.2% Тойрог 8 (Баянзүрх)
42.0% Тойрог 9 (Баянгол)
40.6% Тойрог 13 (Багануур, Багахангай, Налайх)
38.8% Тойрог 11 (Сонгинохайрхан)
38.8% Тойрог 12 (Хан-Уул)
37.8% Тойрог 5 (Дархан-Уул, Сэлэнгэ, Төв)
34.4% Тойрог 10 (Сүхбаатар, Чингэлтэй)
31.3% Тойрог 1 (Архангай, Баянхонгор, Өвөрхангай)
29.9% Тойрог 4 (Булган, Орхон, Хөвсгөл)
27.6% Тойрог 6 (Дорнод, Сүхбаатар, Хэнтий)
23.7% Тойрог 2 (Говь-Алтай, Завхан, Увс, Ховд)
17.4% Тойрог 3 (Баян-Өлгий)

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн нутаг дэвсгэр нь орон нутагт бүсчилсэн долоо, нийслэл Улаанбаатарт зургаа, нийт 13 тойрогт хуваагдсан. Сонгуульд өрсөлдөж буй 1341 нэр дэвшигчийн 969 нь эдгээр 13 тойрогт өрсөлдөж, 372 нь жагсаалтаар сонгогдсон. Тойрогт өрсөлдөж буй 969 нэр дэвшигчийн хүйсийн харьцаа нь эрэгтэй, эмэгтэй харгалзан 65.5% ба 34.5% буюу 635 эрэгтэй, 334 эмэгтэй тойрогт нэр дэвшсэн.

Тойрог бүрийн хувьд хүйсийн харьцааг авч үзвэл УИХ-ын сонгуулийн 7-р тойрогт эмэгтэй нэр дэвшигчдийн эзлэх хувь хамгийн өндөр (42.3%), 3-р тойрогт хамгийн бага (17.4%) байв.

Хэдийгээр нам, эвслийн нэр дэвшүүлэх ажиллагаанд бага хүйсийн төлөөлөл 30% байхаар заасан ч сонгуулийн тойргууд дахь хуваарилалтанд хүйсийн харьцаа 17.4% болж буурч байна.

УИХ-ын сонгуулийн 13 тойргоос 5-р тойрогт хамгийн олон буюу 47 эмэгтэй нэр дэвшигч зэрэг өрсөлдсөн нь онцлогтой. Дархан, Сэлэнгэ, Төв аймгийн томсгосон энэхүү тойрогт улс даяар хамгийн их буюу 119 хүн өрсөлдсөн юм.

Байршлын хувьд төв рүү дөхөх тусам нэр дэвшигчдийн хүйсийн харьцаа илүү тэнцвэртэй болох хандлагатай бол алслагдсан Баруун бүс, Зүүн бүсэд эмэгтэй нэр дэвшигчдийн хувь бага байна.

## УИХ-ЫН СОНГУУЛИЙН 1-Р ТОЙРОГ
Архангай • Баянхонгор • Өвөрхангай




**Мандатын тоо: 9**

**Сонгогчдын тоо**




**Нэр дэвшигчдийн тоо**




## УИХ-ЫН СОНГУУЛИЙН 2-Р ТОЙРОГ
Говь-Алтай • Завхан • Увс • Ховд




**Мандатын тоо: 10**

**Сонгогчдын тоо**




**Нэр дэвшигчдийн тоо**




Эрэгтэй Эмэгтэй

*Нам, эвслийн нэр Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дараалаар, нэр дэвшигчдийн хүйс СЕХ-нд бүртгүүлсэн дараалаар*

## УИХ-ЫН СОНГУУЛИЙН 3-Р ТОЙРОГ
Баян-Өлгий

- Монгол ардын нам
- Ардчилсан нам
- Үндэсний эвсэл
- Иргэний зориг ногоон нам
- Шинэ нэгдсэн эвсэл
- Бүгд найрамдах нам
- Иргэний хөдөлгөөний нам
- ХҮН нам
- Үнэн ба зөв нам
- Эрх чөлөөний эвсэл нам
- Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам
- Бие даан нэр дэвшигч

**Мандатын тоо: 3**

**Сонгогчдын тоо**




**Нэр дэвшигчдийн тоо**




## УИХ-ЫН СОНГУУЛИЙН 4-Р ТОЙРОГ
Булган • Орхон • Хөвсгөл

- Монгол ардын нам
- Ардчилсан нам
- Үндэсний эвсэл
- Иргэний зориг ногоон нам
- Шинэ нэгдсэн эвсэл
- Эх орон нам
- Бүгд найрамдах нам
- Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам
- Иргэний хөдөлгөөний нам
- ХҮН нам
- Монгол консерватив нам
- Ард түмний хүч нам
- Монголын хүний төлөө нам
- Үнэн ба зөв нам
- Эрх чөлөөний эвсэл нам
- Ард түмний олонхийн засаглал нам
- Иргэдийн оролцооны нэгдэл нам
- Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам
- Бие даан нэр дэвшигч

**Мандатын тоо: 8**

**Сонгогчдын тоо**




**Нэр дэвшигчдийн тоо**




Эрэгтэй Эмэгтэй

*Нам, эвслийн нэр Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дараалаар, нэр дэвшигчдийн хүйс СЕХ-нд бүртгүүлсэн дараалаар*

## УИХ-ЫН СОНГУУЛИЙН 5-Р ТОЙРОГ
Дархан-Уул • Сэлэнгэ • Төв

Монгол ардын нам
Ардчилсан нам
Үндэсний эвсэл
Иргэний зориг ногоон нам
Шинэ нэгдсэн эвсэл
Эх орон нам
Бүгд найрамдах нам
Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам
Иргэний хөдөлгөөний нам
ХҮН нам
Монгол консерватив нам
Ард түмний хүч нам
Монголын хүний төлөө нам
Үнэн ба зөв нам
Эрх чөлөөний эвсэл нам
Ард түмний олонхийн засаглал нам
Иргэдийн оролцооны нэгдэл нам
Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам
Бие даан нэр дэвшигч



**Мандатын тоо: 10**

**Сонгогчдын тоо**




**Нэр дэвшигчдийн тоо**




## УИХ-ЫН СОНГУУЛИЙН 6-Р ТОЙРОГ
Дорнод • Сүхбаатар • Хэнтий

Монгол ардын нам
Ардчилсан нам
Үндэсний эвсэл
Иргэний зориг ногоон нам
Шинэ нэгдсэн эвсэл
Эх орон нам
Бүгд найрамдах нам
Иргэний хөдөлгөөний нам
ХҮН нам
Монгол консерватив нам
Ард түмний хүч нам
Монголын хүний төлөө нам
Үнэн ба зөв нам
Эрх чөлөөний эвсэл нам
Ард түмний олонхийн засаглал нам
Иргэдийн оролцооны нэгдэл нам
Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам
Бие даан нэр дэвшигч



**Мандатын тоо: 7**

**Сонгогчдын тоо**




**Нэр дэвшигчдийн тоо**




Эрэгтэй Эмэгтэй

*Нам, эвслийн нэр Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дараалаар, нэр дэвшигчдийн хүйс СЕХ-нд бүртгүүлсэн дараалаар*

## УИХ-ЫН СОНГУУЛИЙН 7-Р ТОЙРОГ

Говьсүмбэр • Дорноговь • Дундговь • Өмнөговь




**Мандатын тоо: 7**

**Сонгогчдын тоо**




**Нэр дэвшигчдийн тоо**




## УИХ-ЫН СОНГУУЛИЙН 8-Р ТОЙРОГ

Баянзүрх




**Мандатын тоо: 5**

**Сонгогчдын тоо**




**Нэр дэвшигчдийн тоо**




Эрэгтэй Эмэгтэй

*Нам, эвслийн нэр Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллаар, нэр дэвшигчдийн хүйс СЕХ-нд бүртгүүлсэн дарааллаар*

## УИХ-ЫН СОНГУУЛИЙН 9-Р ТОЙРОГ

Баянгол




**Мандатын тоо: 3**

**Сонгогчдын тоо**




**Нэр дэвшигчдийн тоо**




## УИХ-ЫН СОНГУУЛИЙН 10-Р ТОЙРОГ

Сүхбаатар • Чингэлтэй




**Мандатын тоо: 6**

**Сонгогчдын тоо**




**Нэр дэвшигчдийн тоо**




Эрэгтэй Эмэгтэй

*Нам, эвслийн нэр Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дараалаар, нэр дэвшигчдийн хүйс СЕХ-нд бүртгүүлсэн дараалаар*

## УИХ-ЫН СОНГУУЛИЙН 11-Р ТОЙРОГ
### Сонгинохайрхан

- Монгол ардын нам
- Ардчилсан нам
- Үндэсний эвсэл
- Иргэний зориг ногоон нам
- Шинэ нэгдсэн эвсэл
- Эх орон нам
- Бүгд найрамдах нам
- Монголын социал демократ нам
- Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам
- Иргэний хөдөлгөөний нам
- ХҮН нам
- Монгол консерватив нам
- Ард түмний хүч нам
- Монголын хүний төлөө нам
- Үнэн ба зөв нам
- Эрх чөлөөний эвсэл нам
- Ард түмний олонхийн засаглал нам
- Иргэдийн оролцооны нэгдэл нам
- Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам
- Бие даан нэр дэвшигч

**Мандатын тоо: 5**

**Сонгогчдын тоо**




**Нэр дэвшигчдийн тоо**




## УИХ-ЫН СОНГУУЛИЙН 12-Р ТОЙРОГ
### Хан-Уул

- Монгол ардын нам
- Ардчилсан нам
- Үндэсний эвсэл
- Иргэний зориг ногоон нам
- Шинэ нэгдсэн эвсэл
- Эх орон нам
- Бүгд найрамдах нам
- Монголын социал демократ нам
- Иргэний хөдөлгөөний нам
- ХҮН нам
- Монгол консерватив нам
- Ард түмний хүч нам
- Монголын хүний төлөө нам
- Үнэн ба зөв нам
- Эрх чөлөөний эвсэл нам
- Ард түмний олонхийн засаглал нам
- Иргэдийн оролцооны нэгдэл нам
- Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам
- Бие даан нэр дэвшигч

**Мандатын тоо: 3**

**Сонгогчдын тоо**




**Нэр дэвшигчдийн тоо**




Эрэгтэй Эмэгтэй

*Нам, эвслийн нэр Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дараалаар, нэр дэвшигчдийн хүйс СЕХ-нд бүртгүүлсэн дараалаар*

## УИХ-ЫН СОНГУУЛИЙН 13-Р ТОЙРОГ

Багануур • Багахангай • Налайх

- Монгол ардын нам
- Ардчилсан нам
- Үндэсний эвсэл
- Иргэний зориг ногоон нам
- Шинэ нэгдсэн эвсэл
- Монголын либерал ардчилсан нам
- Эх орон нам
- Бүгд найрамдах нам
- Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам
- Иргэний хөдөлгөөний нам
- ХҮН нам
- Эх орончдын нэгдсэн нам
- Монгол консерватив нам
- Ард түмний хүч нам
- Үнэн ба зөв нам
- Эрх чөлөөний эвсэл нам
- Ард түмний олонхийн засаглал нам
- Иргэдийн оролцооны нэгдэл нам
- Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам
- Монголын хүний төлөө нам

**Мандатын тоо: 2**

**Сонгогчдын тоо**




**Нэр дэвшигчдийн тоо**




Эрэгтэй Эмэгтэй

*Нам, эвслийн нэр Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллаар, нэр дэвшигчдийн хүйс СЕХ-нд бүртгүүлсэн дараалаар*

## МОНГОЛ АРДЫН НАМ

### Тойрогт нэр дэвшигчид

1 Архангай, Баянхонгор, Өвөрхангай
2 Говь-Алтай, Завхан, Увс, Ховд
3 Баян-Өлгий
4 Булган, Орхон, Хөвсгөл
5 Дархан-Уул, Сэлэнгэ, Төв
6 Дорнод, Сүхбаатар, Хэнтий
7 Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь
8 Баянзүрх
9 Баянгол
10 Сүхбаатар, Чингэлтэй
11 Сонгинохайрхан
12 Хан-Уул
13 Багануур, Багахангай, Налайх

### Жагсаалтаар нэр дэвшигчид




## АРДЧИЛСАН НАМ

### Тойрогт нэр дэвшигчид

1 Архангай, Баянхонгор, Өвөрхангай
2 Говь-Алтай, Завхан, Увс, Ховд
3 Баян-Өлгий
4 Булган, Орхон, Хөвсгөл
5 Дархан-Уул, Сэлэнгэ, Төв
6 Дорнод, Сүхбаатар, Хэнтий
7 Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь
8 Баянзүрх
9 Баянгол
10 Сүхбаатар, Чингэлтэй
11 Сонгинохайрхан
12 Хан-Уул
13 Багануур, Багахангай, Налайх

### Жагсаалтаар нэр дэвшигчид




## ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ

### Тойрогт нэр дэвшигчид

1 Архангай, Баянхонгор, Өвөрхангай
2 Говь-Алтай, Завхан, Увс, Ховд
3 Баян-Өлгий
4 Булган, Орхон, Хөвсгөл
5 Дархан-Уул, Сэлэнгэ, Төв
6 Дорнод, Сүхбаатар, Хэнтий
7 Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь
8 Баянзүрх
9 Баянгол
10 Сүхбаатар, Чингэлтэй
11 Сонгинохайрхан
12 Хан-Уул
13 Багануур, Багахангай, Налайх

### Жагсаалтаар нэр дэвшигчид




